



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/36/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Тэргүүлэх аудитор:

Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enktsetseg.e@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13	Шилэн дансны мэдээлэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.АНХТУЯА ТАНАА
<u>2020.02.17</u> № <u>1-6/74</u> танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын Ажлын албаны дарга А.Анхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.13-аас 2020.02.14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

“Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эхэлсэн ажлуудын тогтвортой байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зорилт 1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг сумын хөгжлийн зорилтуудыг сайтар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.
- Зорилт 2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Зорилт 3. Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Зорилт 4. Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.
- Зорилт 5. ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Зорилт 6. Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2019 оны эхний хагас жилийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшин дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 92,609.6 мянган төгрөгөөс тооцон 926.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын дүн 179,741.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,797.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,370.7 мянган төгрөгөөр буюу 23.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	00	00	
Бараа материал	4,704.1	2,381.1	-2,323.0
Үндсэн хөрөнгө	150,911.8	142,164.3	-8,747.5
Хуримтлагдсан элэгдэл	-74,584.3	-82,884.5	-8,300.2
Нийт хөрөнгө	81,031.6	61,660.9	19,370.7
Өр төлбөр	00	00	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	81,031.6	61,660.9	19,370.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	81,031.6	61,660.9	19,370.7

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2017 онд албан тушаалын байрны засварт зориулж авч зарцуулсан 3629.4 мянган төгрөгийн хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан байсныг бүртгэлээс хасаж залруулсан, ИТХТ-ийн 2019 оны 11/89 дүгээр тогтоолоор ахуйн материалаас 736.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, аудитын залруулгаар аж ахуйн материал, бичиг хэргийн материалын үлдэгдлийг 2043.3 мянган төгрөгөөр нэмж залруулснаас шалтгаалжээ.

Дээрх байхгүй хөрөнгийг үлдэгдэлтэйгээр бүртгэж, тайлагнаж ирсэн нь /аудитын явцад хөрөнгийн түүвэр тооллого хийж биетээр байхгүй хөрөнгийг илрүүлсэн/ тооллогыг нүдээр үзэж, үнэн зөв тоолоогүйгээс оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй, санхүүгийн тайланг буруу илэрхийлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь сумын ИТХТ-ийн 2019 оны 11/89 дүгээр тогтоолоор 6250.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, сумын ИТХТ-ийн 2019 оны 11/90 дүгээр тогтоолоор 2497.3 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ЗДТГ-т шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл дансны буурсан зөрүү нь 16110.7 мянган төгрөгөөр элэгдэл байгуулж, хасагдсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 7810.0 мянган төгрөг байсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 61660.9 мянган төгрөг болж 19370.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн данс 19370.7 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 138,502.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төсөв батлагдсан бөгөөд

нийт зардлын 138,502.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Урсгал зардалд гүйцэтгэлээр 127,591.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийг 10,911.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэгдсэн 10,911.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас олон нийтийн цагдаагийн урамшууллын санхүүжилт 22,201.1 мянган төгрөг авч гүйцэтгэлээр 21,899.9 мянган төгрөг зарцуулж 301.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 24,202.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16,422.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,780.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 7,780.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

1. Хүчин төгөлдөр бус захирамжаар 4 ажилтанд тус бүрд 270.0 мянган төгрөг буюу нийт 1090.0 мянган төгрөгийн түлээ нүүрс, өвлийн хүнсний дэмжлэг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 20.1.4, 20.2.5 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр олгосон дэмжлэгийн 1080.0 мянган төгрөгийг 4 ажилтнаар төлүүлж орон нутгийн төсөвт төлөх төлбөрийн акт тогтоов.

2. Өмнөх оны аудитаар өгсөн 6.7 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, өөрөөр хэлбэл Чандмань бадрал ОНӨ ХХК-аар гүйцэтгүүлэх ажил хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 41.2.7 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чандмань бадрал ОНӨ ХХК-аар 6.7 сая төгрөгийг төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн цалин, НДШ, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалтай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийг үнэн зөв тоолж бүртгэсэн, нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэлээ хөтөлсөн эсэхийг шалгах нь зүйтэй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд сумын ИТХ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 751.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос холбогдох байгууллагаас төлбөрийг барагдуулах албан бичиг авсан, 76,571.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс 69,871.7 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 0 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн, ерөнхий журнал, үр дүнгийн тайлангийн дүн, НД-ын тайлангийн дүн хоорондоо зөрүүтэй байна. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас олгосон дэмжлэг, тусламжийн зардлын баримтын бүрдэл хангалтгүй байна. Энэ нь үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийг үр ашиггүй зүйлд зарцуулах, төсөв хэтрэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 20.2.6 дахь заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,704,100.00	2,381,100.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,704,100.00	2,381,100.00
354	Хангамжийн материал	4,704,100.00	2,381,100.00
35410	Бичиг хэргийн материал	648,300.00	495,600.00
35420	Аж ахуйн материал	1,657,050.00	1,885,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	478,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	1,920,750.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	76,327,511.19	59,279,804.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	76,327,511.19	59,279,804.37
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	76,327,511.19	59,279,804.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	50,829,574.00	50,829,574.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-736,660.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-59,895,833.51	-72,395,833.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,830,173.00	10,387,470.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,567,652.82	-5,911,830.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,252,109.00	5,947,310.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,120,858.48	-3,840,225.64
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	81,031,611.19	61,660,904.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	81,031,611.19	61,660,904.37
51	Засгийн газрын хувь оролцоо	81,031,611.19	61,660,904.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,528,852.86	45,528,852.86
51101	Өмч: - төрийн	45,528,852.86	45,528,852.86
512	Хуримтлагдсан үр дүн	-6,950,510.87	-26,187,680.69
51210	Өмнөх үеийн үр дүн	-6,950,510.87	-6,816,973.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,370,706.82
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,453,269.20	42,319,732.20
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	81,031,611.19	61,660,904.37

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	159,522,685.00	160,703,578.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,365,385.00	22,201,078.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,365,385.00	22,201,078.00
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	00.00
120002	Хүүгийн орлого	00.00	00.00
120003	Торгуулийн орлого	00.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,365,385.00	22,201,078.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,886,185.00	22,201,078.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	151,157,300.00	138,502,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,157,300.00	138,502,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,157,300.00	138,502,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	174,969,839.91	179,137,284.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	174,969,839.91	179,137,284.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,782,195.25	150,522,564.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,763,430.06	60,164,992.00
210101	Үндсэн цалин	53,763,430.06	51,206,487.00
210104	Урамшуулал	00.00	8,958,505.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,382,113.01	7,773,190.00
210201	Тэтгэврийн даатгал	4,287,627.02	5,616,223.00
210202	Тэтгэмжийн даатгал	535,952.00	535,901.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	413,762.39	305,858.00
210204	Ажилгүйдлийн даатгал	102,759.61	119,538.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,042,011.99	1,195,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,072,915.30	23,703,289.00
210401	Бичиг хэрэг	3,753,900.00	2,771,508.00
210402	Тээвэр, шатахуун	3,276,000.00	6,478,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	527,015.30	913,781.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,516,000.00	13,540,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,700,000.00	00.00
210604	Урсгал засвар	12,700,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,716,300.00	6,722,860.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	676,000.00	1,021,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,040,300.00	5,701,860.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,803,147.00	34,795,227.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,628,747.00	34,680,227.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,344,289.88	17,363,006.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,252,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,344,289.88	16,110,706.58
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,187,644.66	28,614,720.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,187,644.66	11,212,721.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	17,401,999.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	17,401,999.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-15,447,154.91	-18,433,706.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	937,000.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	937,000.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-937,000.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-15,447,154.91	-19,370,706.82

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	159,043,485.00	160,703,578.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,886,185.00	22,201,078.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,886,185.00	22,201,078.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,886,185.00	22,201,078.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,886,185.00	22,201,078.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,157,300.00	138,502,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,157,300.00	138,502,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,157,300.00	138,502,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	159,043,485.00	160,703,578.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,043,485.00	160,703,578.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,855,840.34	132,080,858.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,640,865.03	60,156,992.00
210101	Үндсэн цалин	53,640,865.03	48,707,287.00
210104	Урамшуулал	00.00	11,449,705.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,382,113.01	7,773,190.00
210201	Тэтгэврийн даатгал	4,287,627.02	5,396,848.00
210202	Тэтгэмжийн даатгал	535,952.00	535,901.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	413,762.39	525,233.00
210204	Ажилгүйдлийн даатгал	102,759.61	119,538.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,042,011.99	1,195,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,413,115.30	9,332,589.00
210401	Бичиг хэрэг	1,192,100.00	2,418,808.00
210402	Тээвэр, шатахуун	3,694,000.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	527,015.30	913,781.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,396,800.00	00.00
210604	Урсгал засвар	12,396,800.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,716,300.00	8,020,860.00
210702	Дотоод албан томилолт	676,000.00	1,021,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,040,300.00	6,999,860.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,306,647.00	41,044,927.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,132,247.00	40,929,927.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,752,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	5,752,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,187,644.66	28,622,720.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,187,644.66	11,212,721.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	17,409,999.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	17,409,999.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	12,670,950.00	18,171,354.76	00.00	76,371,157.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,528,852.86	12,670,950.00	18,171,354.76	00.00	76,371,157.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,587,342.70	00.00	-6,587,342.70
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	42,453,269.20	-6,950,510.87	00.00	81,031,611.19
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	42,453,269.20	-6,950,510.87	00.00	81,031,611.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	133,537.00	00.00	133,537.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,528,852.86	42,453,269.20	-6,816,973.87	00.00	81,165,148.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-133,537.00	00.00	00.00	-133,537.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,370,706.82	00.00	-19,370,706.82
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	42,319,732.20	-26,187,680.69	00.00	61,660,904.37

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөг	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,502,500.00	127,591,000.00	10,911,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,502,500.00	127,591,000.00	10,911,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,102,500.00	110,181,001.00	8,921,499.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,215,100.00	60,156,992.00	4,058,108.00
210101	Үндсэн цалин	49,912,900.00	48,707,287.00	1,205,613.00
210104	Урамшуулал	14,302,200.00	11,449,705.00	2,852,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,298,100.00	7,773,190.00	524,910.00
210201	Тэтгэврийн даатгал	5,548,700.00	5,396,848.00	151,852.00
210202	Тэтгэмжийн даатгал	549,900.00	535,901.00	13,999.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	687,400.00	525,233.00	162,167.00
210204	Ажилгүйдлийн даатгал	137,400.00	119,538.00	17,862.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,374,700.00	1,195,670.00	179,030.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,558,900.00	9,332,589.00	226,311.00
210401	Бичиг хэрэг	2,418,900.00	2,418,808.00	92.00
210402	Тэвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,000.00	913,781.00	226,219.00
2107	Томилголт, зочны зардал	8,720,400.00	8,020,860.00	699,540.00
210702	Дотоод албан томилголт	1,720,400.00	1,021,000.00	699,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,000,000.00	6,999,860.00	140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,330,300.00	19,145,070.00	3,185,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,020,300.00	19,030,070.00	2,990,230.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	00.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	93,000.00	9,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,000.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,979,700.00	5,752,300.00	227,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,979,700.00	5,752,300.00	227,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,400,000.00	17,409,999.00	1,990,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,400,000.00	17,409,999.00	1,990,001.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,400,000.00	17,409,999.00	1,990,001.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,502,500.00	138,502,500.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	138,502,500.00	138,502,500.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	138,502,500.00	138,502,500.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	-57,281.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	-7,323.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	-4,090.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	-45,868.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	04.00	04.00	0.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	02.00	02.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00	0.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	01.00	01.00	0.00

Төсвийн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		21,899,857.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		21,899,857.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		21,899,857.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		21,899,857.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		21,899,857.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		